



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/335

Булган сум

Г Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2024 оны 09 дүгээр 11-ны өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын Ачуут голын хөндлөн халиа, дошин үүсэхээс урьдчилан сэргийлэх, түр шороон далан үүсгэх ажилд гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж 8,600,000 (найман сая зургаан зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д олгосугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авч, тайлагнахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

3. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

